


2025 ОНЫ 02 ДУГААР САРЫН УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Өвлийн саруудад Монгол орны нутаг дэвсгэр дээгүүр их даралтын орон зонхилон ажиглагддаг тул цаг агаар гол төлөв тогтуун байдаг. Манай орны 2 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон томоохон гол, нуурын сав газраар -18°C (-0.4°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар -6°C (21.2°F) –аас -12°C (10.4°F), бусад нутгаар -12°C –аас -18°C (20.4°F –аас -0.4°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 2 дугаар сард хур тунадас бага унадаг ба ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 1 хувьтай тэнцдэг. Тус сард томоохон гол, нуурын сав газар болон Увс, Хэнтий аймгийн баруун, Завханы хойд хэсгээр 3-4 мм, говь цөлийн бүс нутгаар 0.3-1.4 мм бусад нутгаар 1.5-3 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 2 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2025 оны 2 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс 3.1°C -аар, ОЖД-аас 0.3°C -аар тус тус дулаан байсан бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 27 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нийт нутгийн 32.6% нь ОЖД-аас 1.1°C -ээс - 3.2°C -аар дулаан, 50.4% нь дунджийн орчим, харин 17.1% нь дунджаас хүйтэн байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 0.6 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 82.8%, ОЖД-аас 67.8%-иар тус тус бага буюу 1940 оноос хойш тохиолдож байгаа 6 дахь хур тунадас багатай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн дийлэнх буюу 91.5% нь дунджаас бага, 2.3% -д дунджийн орчим, 6.2% нь дунджаас ахиу хур тунадас унасан байна.




Зураг 2. 2025 оны 2 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын газарзүйн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 2 дугаар сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзэхэд 1 дүгээр 10 хоног болон 2 дугаар 10 хоногийн сүүлээс 3 дугаар 10 хоногийн эхэн хүртэл ихэнх нутгаар ОЖД-аас -0.2°C -аас -7.0°C -аар хүйтэн байсан. Харин 2 болон 3 дугаар 10 хоногийн бусад хугацаанд нийт нутгаар $+0.1^{\circ}\text{C}$ -аас $+10.3^{\circ}\text{C}$ -аар дулаан байжээ. Хур тунадасны хувьд 1 дүгээр 10 хоногт бусад хугацаатай харьцуулахад нийт нутгаар харьцангуй ахиу тунадас орсон байна (Зураг 3).




Зураг 3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Агаарын үнэмлэхүй бага температур -30°C -ыг давж хүйтэрсэн өдрийн тоо Увсын Тэс, Завхан, Улаангом, Завханы Отгон, Цэцэн-Уул, Завханмандал, Баянтэс, Баянхонгорын Байдраг, Ховдын Цэцэг орчмоор 20 өдрөөс олон, бусад нутгаар 5-20 өдөр ажиглагдсан бөгөөд нутгийн өмнөд хэсгээр ажиглагдаагүй.



Зураг 4. -30°C -аас хүйтэн өдрийн тооны газарзүйн тархалт

Энэ сард үнэмлэхүй бага температур Завханын Отгон суманд агаарт -43.8°C , хөрсөнд -45°C хүрч хүйтэрсэн. Үнэмлэхүй их утга Говь-Алтайн аймгийн Тоорой суманд агаарт 11.3°C , Өмнөговийн Даланзадгад суманд хөрсөнд 27°C хүрч ажиглагдсан байна. Хоногт хамгийн ихдээ Увс аймгийн Наранбулаг суманд 28-ний өдөр 5.7 мм тунадас (цас) орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 968.5гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 756.7гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Баянхонгор аймгийн Богд суманд 29 м/с хүрчээ.



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд

2025/03/08

Уур амьсгалын өөрчлөлт нөөцийн судалгааны хэлтэс